# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 21-ны өдөр Дугаар БА-0934/2025 Улаанбаатар хот

## Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 10.0м*4.0м хэмжээтэй, 1 давхар, шатахуун түгээх станцын барилга, 75м3-ийн багтаамжтай 1 ширхэг 3 тасалгаатай хэвтээ цилиндр далд сав бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах түгээх зориулалттай шатахуун түгээх станцын барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 сарын 29-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

## Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/10/31 огноо, 0001598 дугаар, БАЗ2024/0782

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: 2007-ШТС-1057/2020

2.3. Захиалагч: “Шунхлай трейдинг” ХХК оноосон нэр, 9011305022 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5506239 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 2 дугаар хороо, чингисийн өргөн чөлөө, Капитал хаус 3-р давхар, холбоо барих утас: 70073001, 91990579 цахим шуудангийн хаяг Gerelt-Od.Sh@shunkhlai.mn;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Эм Пи Ай консалтантс” ХХК оноосон нэр, 9011099068 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2662671 регистрийн дугаар, БУ19-686/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, үйлдвэрийн баруун бүс, 52 тоот, холбоо барих утас:75750800, 11310816, цахим шуудан хаяг: enkhsaikhan@mpi.mn

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Эм Пи Ай консалтантс” ХХК оноосон нэр, 9011099068 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2662671 регистрийн дугаар, ЗТ11-368/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

дугаар хороо, үйлдвэрийн баруун бүс, 52 тоот, холбоо барих утас:75750800, 11310816, цахим шуудан хаяг: Unurtuya <unuruu@mpi.mn>

2.7. Ашиглагч: "Шунхлай трейдинг" ХХК оноосон нэр, 9011305022 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5506239 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 2 дугаар хороо, чингисийн өргөн чөлөө, Капитал хаус 3-р давхар, холбоо барих утас: 70073001, 91990579 цахим шуудангийн хаяг Adiyasuren.S@shunkhlai.mn;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

☑ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 10.0м*4.0м хэмжээтэй, 1 давхар, шатахуун түгээх станцын барилга, 75м3-ийн багтаамжтай 1 ширхэг 3 тасалгаатай хэвтээ цилиндр далд сав бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах түгээх зориулалттай шатахуун түгээх станцын барилга барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 26 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

## Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 10.0м*4.0м хэмжээтэй, 1 давхар, шатахуун түгээх станцын барилга, 75м3-ийн багтаамжтай 1 ширхэг 3 тасалгаатай хэвтээ цилиндр далд сав бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах түгээх зориулалттай шатахуун түгээх станцын барилга барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо,
Шунхлай трейдинг ХХК-ийн захиалгатай,
Шатахуун түгээх станцын барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Шунхлай трейдинг ХХК-ийн Техник технологи хариуцсан захирал (Ш.Гэрэлт-Од)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САН БҮРТГЭВ.
Объектын дугаар: 78
Огноо: 2025 он 02 сар 21 өдөр
Бүртгэсэн:
УЛААНБААТАР ХОТ ХТМ 1584

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО, ШУНХЛАЙ ТРЕЙДИНГ ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 10.0М*4.0М ХЭМЖЭЭТЭЙ, 1 ДАВХАР, ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН БАРИЛГА, 75М3-ИЙН БАГТААМЖТАЙ 1 ШИРХЭГ 3 ТАСАЛГААТАЙ ХЭВТЭЭ ЦИЛИНДР ДАЛД САВ БҮХИЙ ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХАДГАЛАХ ТҮГЭЭХ ЗОРИУЛАЛТТАЙ ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дугаар сарын 29 — Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Шунхлай трейдинг ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 10.0м*4.0м хэмжээтэй, 1 давхар, шатахуун түгээх станцын барилга, 75м3-ийн багтаамжтай 1 ширхэг 3 тасалгаатай хэвтээ цилиндр далд сав бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах түгээх зориулалттай шатахуун түгээх станцын барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын Операторын байранд 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагт 13 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 12:05 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч — А.Мөнгөн
2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч "Шунхлай трейдинг" ХХК-ийн Техник технологи хариуцсан захирал — Ш.Гэрэлт-Од
3. Хяналт шалгалтыг газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Газрын тос, хийн хяналтын улсын байцаагч — Х.Ганхуяг
4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч — Б.Найрамдал
5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер — Б.Цэрэннадмид
6. Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа — М.Батсайхан
7. Мэдээлэл холбоо ТӨХК,Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар, чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн — Ц.Дагвадорж
8. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын Эрхлэгч — Я.Чулуун
9. Барилга хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн — О.Ундрах
10. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер — Г.Үүрийнгэгээ

11. Эм Пи Ай консалтантс ХХК-ийн зургийн инженер Ц.Мөнх-Эрдэнэ
12. Эм Пи Ай консалтантс ХХК-ийн талбайн инженер А.Бөхбилэгт
13. Ашиглалт хариуцагч Шунхлай трейдинг ХХК-ийн Техник ашиглалтын ахлах инженер Э.Санчир-Од

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 13
- Хүрэлцэн ирсэн -13
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 13

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Шунхлай трейдинг ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 10.0м*4.0м хэмжээтэй, 1 давхар, шатахуун түгээх станцын барилга, 75м3-ийн багтаамжтай 1 ширхэг 3 тасалгаатай хэвтээ цилиндр далд сав бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах түгээх зориулалттай шатахуун түгээх станцын барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Газрын тос, хийн хяналтын улсын байцаагч **Х.Ганхуяг:**

- Хэмжих хэрэгслүүдийг баталгаажуулах
- ШТС-ын эзэмшилийн талбай дээрх тээврийн хэрэгслийн 1 чиглэлтэй байх, орц гарцын тэмдэг тэмдэглэгээг байршуулах
- ШТС-д ослын улмаас шатахуун асгарсан тохиолдолд ШТС-ын эзэмшилийн газраас гадагш тархахааргүй байхаар төлөвлөх, ШТС-ын зам тайлбай орц гарц дээр 0,2 метрээс багагүй өндөр өндөрлөгөө, мөн шатахуунаар бохирдсон газаруудын хур тундас зайлуулах сувгийг ШТС-ын ослын савтай холбох
- ШТС-ын орц гарц хэсэгт явган хүний гарцын хэвтээ тэмдэглэгээг хийж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
- Зэргэлдээ барилга зөвшилцсөн тухай албаэ бичиг үзүүлэх

Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд оруулах

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын /ахлах/ байцаагч **Б.Найрамдал:**

- Холболтын цэг өөрчлөгдсөнтэй холбоотой техникийн нөхцөл шинчилж мэдээллийн санд оруулах
- Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан сунгах
- Хөндлөнгийн байгууллагаар хэмжүүлж актаар баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ:**

- Гадна бохир септик системийн зураг шалгуулах
- Цэвэр бохир ус зөөврөөр хангуулах гэрээг шалгуулах
- Ундны усны гэрээг шалгуулах

ХЯНАЛТ
Барилга байгуу
оруу

- Нөөцийн савны угаалга халдваргүйжүүлэлт хийлгүүлж акт үйлдэж шалгуулах /*Тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгэсэн байх*/
- Септикийн угсралтын үеийн ил далд ажлын акт шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах

Барилга хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, барилга байгууламжийг байнгийн ашиглалтад хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1 -д заасны дагуу норм нормативын төлбөрийг төлөх
- Асгаас хөрсний нягтруулалтын дүгнэлт гаргуулж үзүүлэх
- Операторын байрны суурийн бетоны бат бэхийн лабораторийн дүгнэлтийг нөхөж үзүүлэх
- Мөн Операторын барилгын хана, дээвэр, хучилтын ил далд ажлын Фото акт үзүүлэх

Санал: Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер **Б.Цэрэннадмид:**

- Техникийн нөхцөлийн зориулалт өөрчлөх
- Холболтын протокал шалгуулах
- Гадна цахилгааны холболтын цэг өөрчилсөн тул техникийн нөхцөлд өөрчлөлт хийлгэх
- Гадна цахилгааны батлагдсан ажлын зураг шалгуулах
- Газардуулгын эсэргүүцлийн тусгай зөвшөөрөлтэй компаниар хэмжилт хийлгэж протокал авах
- Аргалант 10кВ-н фидерийн ЦДАШ-г кабель шугам болгосон техникийн нөхцөл, холбогдох зөвшөөрөл шалгуулах
- Гадна, дотор цахаилгааны ил далд ажлын акт шалгуулах
- Гадна цахилгааны цахилгаан дамжуулах кабель шугамыг Нийслэлийн мэдээллийн санд оруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах

Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа **М.Батсайхан:**

- Зэргэлдээх барилгын зай хэмжээ, норм дүрэм, хангаж байгаа эсэхэд тайлбар, баталгаа албан бичиг өгөх
- Галын усан сан батлагдсан зураг төслийн дагуу хийгдээгүй тайлбар өгөх.
- Операторын барилгын гадна хананы тэсвэршилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх
- Галын аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ стандартын дагуу хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар, чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж:**

- Хяналтын камерийг нэмэгдүүлэх
- Камерын дуранг арчиж цэвэрлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын Эрхлэгч **Я.Чулуун:**

- Баримт бичгийг аривын заавар журмын дагуу цэгцлэх. Нүүр хуудa дотоод товъёг хийх, үйлдэх

ШАЛГАЛТ
АЗАР
амжийг аши
ах комисс

- ШТС-ын зураг төсөл, техникийн баримт бичгийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд оруулах

Захиалагч байгууллага Шунхлай трейдинг ХХК-ийн Техник ашиглалтын ахлах инженер **Э.Санчир-Од**

- Тухайлсан саналгүй

Ашиглагч өмчлөгч байгууллага Шунхлай трейдинг ХХК-ийн Байгаль орчин, галын аюулгүй байдал хариуцсан инженер **Б.Лувсандэндэв:**

- Тухайлсан саналгүй

Зураг төсөл зохиогч Эм Пи Ай консалтантс ХХК-ийн зургийн инженер **Ц.Мөнх-Эрдэнэ:**

- Тухайлсан саналгүй

Гүйцэтгэгч байгууллага: Эм Пи Ай консалтантс ХХК-ийн инженер **А.Бөхбилэгт:**

- Тухайлсан саналгүй

Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- Зохиогчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэн бичих
- Барилгын тухай хуулийн дагуу гүйцэтгэгч чанарын баталгааны албан тоотыг ирүүлэх
- ШТС-ын ойр орчмын хэвтээ тэмдэг тэмдэглэгээг стандарт, нормын дагуу байршуулах, засалын ажлыг хийх
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна тохижилтийг хийх

Үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд оруулах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Шунхлай трейдинг ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 10.0м*4.0м хэмжээтэй, 1 давхар, шатахуун түгээх станцын барилга, 75м3-ийн багтаамжтай 1 ширхэг 3 тасалгаатай хэвтээ цилиндр далд сав бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах түгээх зориулалттай шатахуун түгээх станцын барилгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч: (А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Шунхлай трейдинг ХХК-ийн
Техник технологи хариуцсан захирал (Ш.Гэрэлт-Од)